



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс хийсэн гүйцэтгэлийн шалгалтын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн шалгалтын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан байдалд 13 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага, түүний харьяа орон нутгийн салбар сургуулиудад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар газар эзэмших эрхийн хөдлөл өөрчлөлтэй холбоотой 13 нэгж талбарын 13.63 га газрын 1.29 тэрбум төгрөгийн зөрчлийг, 23 барилга байгууламжийн 35.91 тэрбум төгрөгийн зөрчлийг, мөнгөн хөрөнгөтэй холбоотой 0.21 тэрбум төгрөгийн зөрчлийг нийт давхардсан тоогоор 30 дээд боловсролын сургалтын байгууллага 12 арга хэмжээний 37.42 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгасан байна.

Хэрэгжих шатанд 6 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын газар эзэмших/ашиглах эрхийн хөдлөл өөрчлөлтэй холбоотой 15 нэгж талбарын газар, 3 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авах, хасахтай холбоотой 4 асуудлууд 50-80 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу үнэлэхэд 13 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага хамрагдсанаас 10 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага “Бүрэн хангалттай”, 2 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага “Хангалттай”, 1 төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага “Хангалтгүй” буюу дундаж үнэлгээ 87.49 хувь “Бүрэн хангалттай” байгаа тухай танилцуулав.

Д/д	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын нэр	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээ/хувь	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хүрсэн түвшин
1	Монгол Улсын их сургууль	34	90	Бүрэн хангалттай
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	25	90	Бүрэн хангалттай
3	Шинжлэх ухааны технологийн их сургууль	15	80.6	Хангалттай
4	Монгол Улсын боловсролын их сургууль	10	90	Бүрэн хангалттай
5	Монгол Улсын Консерваторийн сургууль	10	89	Бүрэн хангалттай
6	Хөдөө аж ахуйн их сургууль	9	81.1	Хангалттай
7	Монгол Германы хамтарсан технологийн их сургууль	8	95	Бүрэн хангалттай
8	Дотоод хэргийн их сургууль	6	91.7	Бүрэн хангалттай
9	Монгол Улсын соёл урлагийн их сургууль	5	85	Бүрэн хангалттай
10	Төмөр замын дээд сургууль	4	100	Бүрэн хангалттай
11	Удирдлагын академийн сургууль	4	85	Бүрэн хангалттай
12	Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн сургууль	3	93	Бүрэн хангалттай
13	Үндэсний батлан хамгаалахын их сургууль	3	67	Хангалтгүй
Үнэлгээний дундаж хувь			87.49	Бүрэн хангалттай

Цаашид 50-80 хувьтай хэрэгжих шатанд байгаа ашиглалтгүй, маргаантай хөрөнгө, газрын асуудлаар тодорхой ажил зохион байгуулж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар арга хэмжээ авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага нарт үүрэг болгов. гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

